



**2021 оны Намрын улиралд суралцагчдыг Хамрах хүрээний Үйл явц: Баталсан тухай Мэдэгдэл  
Захидал: 46110, 46120, 46111, 48160, 48180, 48290, 46140, 48150, 48280, 48281 төлөвлөлтийн  
нэгжүүдэд оршин суудаг 8 дугаар ангид суралцагчдын гэр бүлийнхэн**

2021 оны 12 сарын 10

Хүндэт 8 дугаар ангид суралцагчдын гэр бүлийнхэн Танаа:

2021 оны 12-р сарын 2-ны өдөр Сургуулийн Удирдах Зөвлөл 2022 оны 8-р сараас хэрэгжүүлж эхлэх 2021 оны Намрын улиралд суралцагчдыг Хамрах хүрээний Өөрчлөлтийг батлан санал хураалаа.

2022-23 оны хичээлийн жилд 46110, 46120, 46111, 48160, 48180, 48290, 46140, 48150, 48280, 48281 төлөвлөлтийн нэгжүүдийн суралцагчдыг Уэйкфилд сургуулиас Вашингтон-Либерти Ахлах Сургууль руу шилжүүлэн суралцуулахаар болсон. Энэхүү өөрчлөлт нь 9-р ангид элсэн орох бүх сурагчид (2021-22 онд 8-р ангид суралцагчид) болон дээр дурдсан төлөвлөлтийн нэгжид оршин сууж буй ахлах ангийн бүх сурагчдад хамаарна. Хос Хэлний Сургалттай хөтөлбөрт хамрагддаг сурагчид Уэйкфилд Ахлах Сургуульд хөтөлбөрүүдээ үргэлжлүүлэн суралцах боломжтой. Тодруулбал, дээрх төлөвлөлтийн нэгжүүдийн аль нэгэнд амьдардаг, 2021 оны 6-р сарын 17-ноос өмнө Уэйкфилд сургуульд суралцаж байгаа 9-11 дугаар ангийн сурагчид 12-р ангиа тус сургуульд дүүргэх эсвэл шинээр төлөвлөгдсөн зэргэлдээх сургууль (Вашингтон-Либерти Ахлах Сургууль)-д 2022-23 оны хичээлийн жилээс эхлэн суралцах боломжтой.

#### **Ах, эгч дүүс болон Тээвэрлэлтийн талаарх Мэдээлэл**

- **Ах, эгч дүүс** : Уэйкфилд сургуулийн 9-11 дүгээр ангийн сурагчдын 8-р ангид суралцдаг дүү нар нь Уэйкфилд сургууль руу шилжих боломжтой тул 2022-23 оны хичээлийн жилд ах, эгчийнхээ хамт Уэйкфилд Дунд Сургуульд элсэн орж суралцах боломжтой. Эдгээр сурагчдын гэр бүл бүрт захидал, маягтуудыг тус тусад нь илгээнэ.
- **Тээвэрлэлт** : АУС нь Вашингтон-Либерти Ахлах Сургууль (шинээр төлөвлөгдсөн зэргэлдээх сургууль)-д элсэн орсон зорчих бүсээс гадна оршдог дээрх төлөвлөлтийн нэгжүүдэд амьдардаг сурагчдад тээврийн хэрэгслээр үйлчилнэ. Дунд сургуулийн нэмэлт сургууль/хөтөлбөрт хамрагдаж байгаа суралцагчдад мужийн төвлөрсөн зогсоолоос АУС-ийн тээврийн хэрэгслээр үйлчлэх болно.

Хэрэв та бүхэнд тодруулах зүйл байвал [engage@apsva.us](mailto:engage@apsva.us) хаяг руу цахим шуудан илгээх эсвэл Төлөвлөлт, Үнэлгээний албатай 703-228-2481 утсаар холбогдон авна уу. 2021 оны Намрын улирлын Хамрах хүрээний Үйл явцын талаарх нэмэлт мэдээллийг <https://www.apsva.us/engage/fall-2021-boundary-process> холбоосоор орж авна уу.

Баярлалаа,

Лиза Стенгл  
Төлөвлөлт, Үнэлгээний Албаны Дарга  
Арлингтоны Улсын Сургууль